



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/037/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261815 Цахим хаяг: <a href="mailto:chantsaldulamp@audit.gov.mn">chantsaldulamp@audit.gov.mn</a> Аудитор: Т.Баасанцэнд Утас: 261815 Цахим хаяг: <a href="mailto:baasantsendt@audit.gov.mn">baasantsendt@audit.gov.mn</a> Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди-Аудит ХХК Захирал: Д.Эхбаяр Утас: 99116948 Цахим хаяг: <a href="mailto:ekhbayar@sgmd-audit.mn">ekhbayar@sgmd-audit.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1059  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Юнитель ХХК-тай байгуулсан №ТГ21/13-01, Uni21/0546-01, Uni2/1310 тоот түрээсийн гэрээний 13.4 сая төгрөгийн төлбөрийг аваагүй;
- Жилийн эцэст 12.1 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Тайлант онд нийт 43.0 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгэж, тайлагнасан;
- Мобиком ХХК-аас авах 20.3 сая төгрөгийн авлагыг тайланд илэрхийлээгүй, зардлын дансанд хааж бүртгэсэн;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.6, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Z:\Yawsan\_Bichig\2025\0317 SNAG-13.Docx

1525070950

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Тус газрын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу 136 төрлийн 39.2 сая төгрөгийн өртөг бүхий бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг акталсан.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас олгосон 2,424.8 сая төгрөгийн татаас санхүүжилтийг 5 аймгийн радио телевизийн сүлжээний газарт дамжуулан хуваарилж, тайлагнасан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн болно. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,230,248,581.76</b>	<b>2,084,550,967.71</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>216,444,714.44</b>	<b>48,766,417.57</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,330,751.73</b>	<b>3,058,557.73</b>
31110	Төгрөг	1,330,751.73	3,058,557.73
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>215,113,962.71</b>	<b>45,707,859.84</b>
3121	Төгрөг	214,991,757.69	45,664,456.87
31211	Төрийн сангийн харилцах	147,270.16	237,699.43
31213	Арилжааны банк дахь харилцах	214,844,487.53	45,426,757.44
3122	Гадаад валют	122,205.02	43,402.97
31223	Арилжааны банк дахь харилцах	122,205.02	43,402.97
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>45,647,367.00</b>	<b>85,474,496.12</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	28,322,117.00	72,449,346.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>17,325,150.00</b>	<b>13,025,150.12</b>
3351	Байгууллагаас авах авлага	-	1,100,000.12
3352	Хувь хүмүүсээс авах авлага	17,325,150.00	11,925,150.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>5,282,500.00</b>	<b>450,000.00</b>
34713	Томилолтын урьдчилгаа	5,282,500.00	450,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,962,874,100.32</b>	<b>1,949,860,054.02</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,962,874,100.32</b>	<b>1,949,860,054.02</b>
35410	Бичиг хэргийн материал	11,013,606.00	14,963,436.00
35420	Аж ахуйн материал	23,729,360.66	30,855,591.86
35430	Сэлбэг хэрэгсэл	1,697,588,223.10	1,667,068,628.10
35440	Түлш, шатах тослох материал	25,685,473.56	18,918,156.06
35470	Бусад хангамжийн материал	204,857,437.00	218,054,242.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>77,817,932,125.44</b>	<b>76,638,707,917.20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>77,817,932,125.44</b>	<b>76,638,707,917.20</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>10,653,649,629.56</b>	<b>9,465,540,469.44</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,703,936,521.85	5,703,936,521.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,221,654,145.96)	(1,454,561,433.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	557,993,471.00	503,570,621.09
39204	Хуримтлагдсан элэгдэл	(397,274,512.89)	(445,686,831.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,982,599,176.96	16,394,465,353.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,050,864,923.60)	(11,308,860,518.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	203,767,717.81	212,842,777.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(132,336,944.46)	(145,458,716.17)
39209	Зам, гүүрийн байгууламж	37,854,750.00	37,854,750.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(37,469,625.12)	(37,854,750.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,503,422.00	41,503,422.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(34,405,278.03)	(36,210,725.75)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>67,174,682,543.92</b>	<b>67,173,167,447.76</b>
39301	Програм хангамж	23,877,144.00	40,892,144.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,680,048.00)	(21,050,096.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,161,135,400.00	67,161,135,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(6,050,000.12)	(7,810,000.16)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>80,048,180,707.20</b>	<b>78,723,258,884.91</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,863,611.00</b>	<b>10,496,779.79</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,863,611.00</b>	<b>10,496,779.79</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>15,863,611.00</b>	<b>10,496,779.79</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	72,089.00	2,296,779.79
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,759,680.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>14,031,842.00</b>	<b>8,200,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	13,600,000.00	8,200,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	431,842.00	-

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>80,032,317,096.18</b>	<b>78,712,762,105.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>85,141,802,451.94</b>	<b>86,576,701,133.39</b>
51101	Өмч:- төрийн	80,210,908,069.87	80,210,908,069.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(5,109,485,355.76)</b>	<b>(7,863,939,028.27)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,109,485,355.76)	(5,108,956,523.16)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(2,754,982,505.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,930,894,382.07	6,365,793,063.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>80,048,180,707.20</b>	<b>78,723,258,884.91</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,837,298,432.01</b>	<b>7,494,042,972.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,140,258,432.01</b>	<b>993,224,305.53</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,094,684,233.01</b>	<b>993,224,305.53</b>
120002	Хүүгийн орлого	2,844,370.90	2,361,581.77
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	957,909,626.86	957,777,390.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	237,557,581.95	237,576,284.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	625,376,828.91	719,117,053.81
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	94,975,216.00	1,084,052.00
120009	Бусад орлого	133,930,235.25	33,085,333.71
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	45,574,199.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	45,574,199.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,697,040,000.00</b>	<b>6,500,818,667.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төсвөөс</b>	<b>5,697,040,000.00</b>	<b>6,434,196,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,697,040,000.00	6,434,196,200.00
<b>1311</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	<b>66,622,467.00</b>
131103	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	66,622,467.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,417,039,856.15</b>	<b>10,248,944,972.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,417,039,856.15</b>	<b>10,248,944,972.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,219,582,748.15</b>	<b>10,017,204,308.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,904,688,674.81</b>	<b>3,596,066,984.19</b>
210101	Үндсэн цалин	2,904,688,674.81	3,476,552,516.19
210102	Нэмэгдэл	-	29,298,650.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	-	32,625,000.00
210104	Урамшуулал	-	39,283,418.00
210105	Гэрээт ажлын захидал	-	18,247,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>358,397,492.94</b>	<b>438,097,806.10</b>
210201	Тэтгэврийн даатгал	244,478,071.83	297,724,149.44
210202	Тэтгэмжийн даатгал	28,362,210.36	35,464,203.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,754,544.85	20,574,027.62
210204	Ажилгүйдлийн даатгал	6,026,394.59	14,461,286.35
210205	Эрүүл мэндийн даатгал	56,776,271.31	69,874,039.20
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,592,371,975.12</b>	<b>1,756,087,501.02</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,468,594,673.26	1,625,884,501.52
210302	Түлш, халаалт	97,432,472.22	101,893,232.50
210303	Цэвэр, бохир ус	24,333,429.64	25,975,367.00
210304	Байрны түрээс	2,011,400.00	2,334,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>209,064,949.56</b>	<b>179,148,920.52</b>
210401	Бичиг хэрэг	11,831,150.00	15,871,470.00

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210402	Тээвэр, шатахуун	97,650,465.00	99,904,399.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,077,032.58	28,083,976.83
210404	Ном, хэвлэл	495,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,177,777.78	3,964,488.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,135,440.22	28,807,185.80
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,740,879.98	2,517,400.00
210408	Бараа материал акталсны зардал	45,956,304.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,850,650.00</b>	<b>27,999,600.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,850,650.00	27,999,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>383,806,154.43</b>	<b>520,269,098.07</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,507,000.00	11,731,978.00
210602	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	12,760,990.00	20,356,350.00
210604	Урсгал засвар	366,538,164.43	488,180,770.07
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>93,571,963.00</b>	<b>103,024,349.10</b>
210701	Гадаад албан томилолт	6,008,985.00	27,928,829.10
210702	Дотоод албан томилолт	87,562,978.00	75,095,520.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>764,237,803.11</b>	<b>558,821,694.89</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	249,625,191.93	134,355,762.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,844,000.00	19,852,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	18,050,625.00	20,850,665.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,816,647.00	2,188,473.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	402,500.00	220,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	142,779,754.00	146,106,857.00
210807	Газрын төлбөр	323,443,112.00	234,355,105.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,275,973.18	892,232.15
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,909,593,085.18</b>	<b>2,837,748,354.81</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,765,700.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,845,000.00	14,900,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,892,182,385.18	2,822,848,354.81
210904	Найдваргүй авлагын алдагдал	800,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>197,457,800.00</b>	<b>231,740,664.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>197,457,800.00</b>	<b>231,740,664.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	29,178,330.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	126,412,867.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,574,199.00	66,622,467.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	151,882,909.00	9,527,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(2,579,741,424.14)</b>	<b>(2,754,902,000.17)</b>
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>66,654.22</b>	<b>80,504.94</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	66,654.22	80,504.94
<b>7</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(2,579,808,078.36)</b>	<b>(2,754,982,505.11)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>6,724,085,830.94</b>	<b>7,406,326,368.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>981,471,631.84</b>	<b>905,507,701.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>981,471,631.84</b>	<b>905,507,701.00</b>
120002	Хүүгийн орлого	2,844,370.90	2,361,581.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	844,697,025.69	884,755,807.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	237,557,581.95	234,256,184.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	607,139,443.74	650,499,622.81
120009	Бусад орлого	133,930,235.25	18,390,312.18
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,742,614,199.00</b>	<b>6,500,818,667.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>5,697,040,000.00</b>	<b>6,434,196,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,697,040,000.00	6,434,196,200.00
<b>131003</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>45,574,199.00</b>	<b>66,622,467.00</b>
131004	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,574,199.00	66,622,467.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>6,406,024,999.12</b>	<b>7,449,526,346.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,406,024,999.12</b>	<b>7,449,526,346.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,208,694,391.12</b>	<b>7,217,785,682.95</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,904,453,870.03</b>	<b>3,593,809,083.28</b>
210101	Үндсэн цалин	2,883,048,870.03	3,558,872,183.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,689,500.00
210104	Гэрээт ажлын цалин	21,405,000.00	18,247,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>354,579,751.79</b>	<b>436,733,794.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	241,775,103.73	296,796,614.31
210202	Тэтгэмжийн даатгал	28,067,569.95	35,355,083.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	22,518,834.93	20,510,481.19
210204	Ажилгүйдлийн даатгал	5,967,467.67	14,415,815.43
210205	Эрүүл мэндийн даатгал	56,250,775.51	69,655,800.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,600,884,974.40</b>	<b>1,753,160,546.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,464,428,262.26	1,624,058,029.52
210302	Түлш, халаалт	110,111,882.50	100,792,750.00
210303	Цэвэр, бохир ус	24,333,429.64	25,975,367.00
210304	Байрны түрээс	2,011,400.00	2,334,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>178,556,632.58</b>	<b>184,705,623.83</b>
210401	Бичиг хэрэг	14,944,700.00	19,815,220.00
210402	Тээвэр, шатахуун	110,445,806.00	94,913,192.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,164,386.58	28,062,496.83
210404	Ном, хэвлэл	495,900.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	3,875,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,405,840.00	38,039,115.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,988,450.00</b>	<b>45,278,900.00</b>
210502	Хоол, хүнс	-	567,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,988,450.00	44,711,900.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>312,930,078.99</b>	<b>557,863,490.67</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	77,111,398.00	75,061,950.00
210602	Тавилга	-	3,130,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,677,040.00	28,160,880.00
210604	Урсгал засвар	212,141,649.99	451,510,660.07
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>94,584,153.00</b>	<b>98,213,699.10</b>
210701	Гадаад албан томилолт	10,841,485.00	23,096,329.10
210702	Дотоод албан томилолт	83,742,668.00	75,117,370.00

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>745,871,471.33</b>	<b>533,120,545.68</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,632,760.15	137,600,813.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,844,000.00	15,052,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,707,075.00	20,850,665.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,816,647.00	2,198,225.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	454,000.00	220,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,697,904.00	121,950,905.00
210807	Газрын төлбөр	323,443,112.00	234,355,105.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,275,973.18	892,232.16
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,845,000.00</b>	<b>14,900,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,845,000.00	14,900,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>197,330,608.00</b>	<b>231,740,664.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>197,330,608.00</b>	<b>231,740,664.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	29,178,330.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	126,412,867.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,574,199.00	66,622,467.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	151,756,409.00	9,527,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>318,060,831.72</b>	<b>(43,199,978.95)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>133,489,472.00</b>	<b>124,397,813.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>133,489,472.00</b>	<b>124,397,813.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>133,489,472.00</b>	<b>124,397,813.00</b>
222001	Тоног төхөөрөмж	-	124,397,813.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	133,489,472.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(133,489,472.00)</b>	<b>(124,397,813.00)</b>
<b>225</b>	<b>Гадаад валютын ханшийн зөрүү</b>	<b>66,654.23</b>	<b>80,504.94</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүү	66,654.23	80,504.94
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(66,654.23)</b>	<b>(80,504.94)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>184,504,705.50</b>	<b>(167,678,296.88)</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,940,008.94	216,444,714.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	216,444,714.44	48,766,417.57

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>80,210,908,069.87</b>	<b>4,580,281,937.77</b>	<b>(2,180,632,894.48)</b>	<b>82,610,557,113.16</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(349,044,382.92)	(349,044,382.92)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(2,529,677,277.40)	(2,529,677,277.40)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	350,612,444.30	-	350,612,444.30
Тайлант үеийн үр дүн	-	-	(2,529,808,078.36)	(2,529,808,078.36)
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>80,210,908,069.87</b>	<b>4,930,894,382.07</b>	<b>(5,109,485,355.76)</b>	<b>80,032,317,096.18</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	528,832.60	528,832.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	80,210,908,069.87	4,930,894,382.07	(5,108,956,523.16)	80,032,845,928.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	1,434,898,681.445	-	1,434,898,681.445
Тайлант үеийн үр дүн	-	-	(2,754,982,505.11)	(2,754,982,505.11)
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>80,210,908,069.87</b>	<b>6,365,793,063.52</b>	<b>(7,863,939,028.27)</b>	<b>78,712,762,105.12</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,036,061,849.41</b>	<b>7,573,924,159.95</b>	<b>(267,862,310.54)</b>	<b>103.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,036,061,849.41</b>	<b>7,573,924,159.95</b>	<b>(267,862,310.54)</b>	<b>103.6</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,681,676,071.41</b>	<b>7,217,785,682.95</b>	<b>(536,109,611.54)</b>	<b>108.0</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,210,680,480.07</b>	<b>3,593,809,083.28</b>	<b>(383,128,603.21)</b>	<b>111.9</b>
Үндсэн цалин	3,172,949,080.07	3,558,872,183.28	(385,923,103.21)	112.2
Унаа хоолны Хөнгөлөлт	19,484,000.00	16,689,500.00	2,794,500.00	85.7
Гэрээт ажлын цалин	18,247,400.00	18,247,400.00	-	100.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>394,891,985.81</b>	<b>436,733,794.46</b>	<b>(41,841,808.65)</b>	<b>110.6</b>
Тэтгэврийн даатгал	267,003,277.24	296,796,614.31	(29,793,337.07)	111.2
Тэтгэмжийн даатгал	31,984,000.47	35,355,083.12	(3,371,082.65)	110.5
ҮОМШӨ-ний даатгал	24,516,803.26	20,510,481.19	4,006,322.07	83.7
Ажилгүйдлийн даатгал	7,419,885.89	14,415,815.43	(6,995,929.54)	194.3
Эрүүл мэндийн даатгал	63,968,018.95	69,655,800.41	(5,687,781.46)	108.9
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,685,213,800.36</b>	<b>1,753,160,546.52</b>	<b>(67,946,746.16)</b>	<b>104.0</b>
Гэрэл, цахилгаан	1,569,806,130.36	1,624,058,029.52	(54,251,899.16)	103.5
Түлш, халаалт	86,156,890.00	100,792,750.00	(14,635,860.00)	117.0
Цэвэр, бохир ус	21,730,820.00	25,975,367.00	(4,244,547.00)	119.5
Байрны түрээс	7,519,960.00	2,334,400.00	5,185,560.00	31.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>188,861,225.92</b>	<b>184,705,623.83</b>	<b>4,155,602.09</b>	<b>97.8</b>
Бичиг хэрэг	20,157,940.00	19,815,220.00	342,720.00	98.3
Тээвэр, шатахуун	97,467,533.00	94,913,192.00	2,554,341.00	97.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,745,412.92	28,062,496.83	(317,083.91)	101.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	3,875,600.00	124,400.00	96.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	39,490,340.00	38,039,115.00	1,451,225.00	96.3
<b>Нормативт зардал</b>	<b>39,559,760.00</b>	<b>45,278,900.00</b>	<b>(5,719,140.00)</b>	<b>114.5</b>
Хоол, хүнс	1,425,860.00	567,000.00	858,860.00	39.8
Нормын хувцас, зөөлөн эдлэл	38,133,900.00	44,711,900.00	(6,578,000.00)	117.2
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>503,700,360.00</b>	<b>557,863,490.07</b>	<b>(54,163,130.07)</b>	<b>110.8</b>
Багаж, техник, хэрэгсэл	105,948,490.00	75,061,950.00	30,886,540.00	70.8
Тавилга	3,130,000.00	3,130,000.00	-	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	37,136,980.00	28,160,880.00	8,976,100.00	75.8
Урсгал засвар	357,484,890.00	451,510,660.07	(94,025,770.07)	126.3
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>97,373,730.00</b>	<b>98,213,699.10</b>	<b>(839,969.10)</b>	<b>100.9</b>
Гадаад албан томилолт	23,096,320.00	23,096,329.10	(9.10)	100.0
Дотоод албан томилолт	74,277,410.00	75,117,370.00	(839,960.00)	101.1
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>546,494,729.25</b>	<b>533,120,545.68</b>	<b>13,374,183.57</b>	<b>97.6</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	167,822,600.00	137,600,813.53	30,221,786.47	82.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,918,600.00	15,052,600.00	(2,134,000.00)	116.5
Даатгалын үйлчилгээ	25,357,325.00	20,850,665.00	4,506,660.00	82.2
Тээврийн хэрэгслийн татвар	2,529,640.00	2,198,225.00	331,415.00	86.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	224,000.00	220,000.00	4,000.00	98.2
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	115,624,990.00	121,950,905.00	(6,325,915.00)	105.5
Газрын төлбөр	221,042,200.00	234,355,105.00	(13,312,905.00)	106.0

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	975,374.25	892,232.16	83,142.10	91.5
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,900,000.00</b>	<b>14,900,000.00</b>	-	<b>100.0</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,900,000.00	14,900,000.00	-	100.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>138,060,129.00</b>	<b>231,740,664.00</b>	<b>(93,680,535.00)</b>	<b>167.9</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43,733,640.00	29,178,330.00	14,555,310.00	66.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,399,489.00	126,412,867.00	(42,013,378.00)	149.8
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэ	-	66,622,467.00	(66,622,467.00)	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	9,927,000.00	9,527,000.00	400,000.00	96.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>21,000,000.00</b>	<b>124,397,813.00</b>	<b>(103,397,813.00)</b>	<b>592.4</b>
Тоног төхөөрөмж	21,000,000.00	124,397,813.00	(103,397,813.00)	592.4
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,719,766,747.00</b>	<b>7,403,964,786.24</b>	<b>(684,198,039.24)</b>	<b>110.2</b>
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>5,868,436,817.00</b>	<b>6,434,196,200.00</b>	<b>(565,759,383.00)</b>	<b>109.6</b>
Улсын төсвөөс санхүүжих	5,868,436,817.00	6,434,196,200.00	(565,759,383.00)	109.6
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>66,622,467.00</b>	<b>(66,622,467.00)</b>	-
Орон нутгийн төсвөөс	-	66,622,467.00	(66,622,467.00)	-
<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>851,329,930.00</b>	<b>903,146,119.24</b>	<b>(51,816,189.24)</b>	<b>106.1</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	234,256,180.00	234,256,184.25	(4.25)	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	617,073,750.00	668,889,934.99	(51,816,184.99)	108.4
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>216,444,714.45</b>	-	-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>48,766,417.57</b>	-	-
Ажилчдын тоо	228	228	-	100.0
Удирдах	6	6	-	100.0
Гүйцэтгэх	220	220	-	100.0
Үйлчлэх ажилтан	2	2	-	100.0

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 108.6 сая төгрөгийн 8 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 15.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 12.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 81.0 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Юнитель ХХК-тай байгуулсан №ТГ21/13-01, Uni21/0546-01, Uni2/1310 тоот түрээсийн гэрээний 13.4 сая төгрөгийн төлбөрийг аваагүй байна.	1	13,380.0	1	13,380.0	-	-	-	-	-	-	-	-	-
Тус улсын төсөвт үйлдвэрийн газрын албаны даргын Удирдлагын академид суралцсан төлбөрт 2.2 сая төгрөгийг байгууллагаас төлсөн.	1	2,160.0	1	2,160.0	-	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд 12.1 сая төгрөгийн төлбөртэй үйлчилгээний авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна	1	12,081.9	-	-	1	12,081.9	-	-	-	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Тайлант онд нийт 43.0 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу бүртгэж, тайлагнасан байна. Тухайлбал, <ul style="list-style-type: none"> <li>• Нийт 18.1 сая төгрөгийн өртөг бүхий байгууллагын WEB хуудсыг нэр бүхий иргэнээр гүйцэтгүүлсэн боловч гэрээний дагуу хүлээлцсэн акт, гүйцэтгэлийн тайлан дутуу;</li> <li>• Бэстватт ХХК-иас 4.0 сая төгрөгийн үнэ бүхий мотор худалдан авсан боловч төлбөрийн баримт (и-баримт) бүрдээгүй;</li> <li>• Тайлант оны эцсээр нэр бүхий ажилтанд хоёр удаагийн томиллолтоор нийт 4.6 сая төгрөг олгосон боловч томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй байна.</li> </ul>	1	43,013.2	-	-	-	-	1	43,013.2	-	-	-	-
Байгууллагын хөрөнгөнд бүртгэлгүй 52-28 УБӨ улсын дугаартай тээврийн хэрэгсэлд 5.1 сая төгрөгөөр засвар хийлгэсэн байна.	1	5,134.8	-	-	-	-	1	5,134.8	-	-	-	-
Өмнөх онуудад үүссэн 14 харилцагчийн 12.1 сая төгрөгийн авлага, ажилчдад олгосон 0.4 сая төгрөгийн томилолтын урьдчилгааг барагдуулаагүй байна.	1	12,531.8	-	-	-	-	1	12,531.8	-	-	-	-
Мобиком ХХК-аас авах 20.3 сая төгрөгийн авлагыг тайланд илэрхийлээгүй, зардлын дансанд хааж бүртгэсэн байна.	1	20,288.9	-	-	-	-	1	20,288.9	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>108,590.6</b>	<b>2</b>	<b>15,540.0</b>	<b>1</b>	<b>12,081.9</b>	<b>5</b>	<b>80,968.7</b>	-	-	-	-

**3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 236.9 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 103.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 133.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>						
Тайлант онд “шилэн дансны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ” хэсэгт мэдээлэх 13.0 сая төгрөг, “шилэн дансны таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт мэдээлэх 19.8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.	1	32,851.3	-	-	1	32,851.3
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>32,851.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>32,851.3</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
Тайлант онд 103.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг шууд худалдан авалтаар зохион байгуулсан байна.	1	102,983.3	1	102,983.3	-	-
Сонгон шалгаруулалтгүй, мэргэшсэн төсөвчнөөр батлуулсан төсөв байхгүй барилгын засварын ажлыг хийж гүйцэтгүүлсэн, засварын ажил хүлээлцсэн акт байхгүй байна.	1	101,080.3	-	-	1	101,080.3
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>204,063.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>101,080.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>236,916.7</b>	<b>1</b>	<b>102,983.3</b>	<b>2</b>	<b>133,933.4</b>